



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/13/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Э.Нандинчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль



Агуулга

Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
3.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
3.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
3.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
3.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	15
3.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



Аудитын гэрчилгээ

СЭРГЭЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ П.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.



Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал П.Эрдэнэцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, гэрээт аудитор О.Эрдэнэтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих”-д оршино.

Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- хүүхдийн хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах
- эх хэлний сургалтын чанарыг нэмэгдүүлэх
- дугуйланд бүх сурагчдыг хамруулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "AXPLORE" программ хангамж ашигладаг байна.

Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 32 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 509,462.9 мянган төгрөгөөс тооцон 7,642.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд хэвээр баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 80,872.4 мянган төгрөгөөр буюу 7,6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,367.3	-	-1,367.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	73,967.7	90,132.6	16,164.9
Үндсэн хөрөнгө	1,053,922.1	1,175,641.5	121,719.4
Элэгдэл	64,290.0	119,934.6	-55,644.6
Нийт хөрөнгө	1,064,967.0	1,145,839.4	80,872.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,064,967.0	1,145,839.4	80,872.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,064,967.0	1,145,839.4	80,872.4

Авлага, өглөгийн дансны үлдэгдэлгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант хугацаанд сургуулийн ой болж, төгсөгчдийн хандиваар 9,100.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, батлагдсан төсвөөс 7,064.9 мянган төгрөгийн тоглолтын хувцас, хэрэглэл худалдан авсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 81,560.0 мянган төгрөгийн боловсон ариун цэврийн байгууламж, 27,500.0 мянган төгрөгийн гүний худаг, хашаажуулалт, сургуулийн төгсөгчдийн хандиваар өгсөн 10,806.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авч сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор 1,853.4 мянган төгрөгийн хөрөнгийг ЗДТГ-аас шилжүүлж авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталсан хөрөнгө байхгүй.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт гараагүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл мянган төгрөг болж 80,872.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 468,176.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 468,176.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 432,676.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжих тусгай зориулалтын шилжүүлгээр, 35,500.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 468,172.3.0 мянган төгрөг буюу 99,9 хувьтай.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 200.0 мянган төгрөгийн “Амьд байгаль” төслийн санхүүжилт ирсэн. Үүнийг зориулалтын дагуу зарцуулж, худалдан авсан хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгасан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 31 эрсдэл тодорхойлж нийт 31 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 3,083.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 147.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,935.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Худалдан авалт, гэрээний биелэлт, хэрэгжилт

Хүүхдийн хоолны материал худалдан авахдаа гэрээнд заасан үнээс илүү үнээр худалдан авч 2,935.4 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь 2 төрлийн махны үнийг дундажлан тооцсонтой холбоотой байгаа бөгөөд *Төсвийн тухай хуулийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* гэсэн заалтад нийцэхгүй санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 147.7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь *Төсвийн тухай хуулийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

[Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургууль](#) нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 145 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид [Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн](#) 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургууль 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

СТ-1А

3.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>75,335,020.08</u>	<u>90,132,668.08</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	73,967,717.08	90,132,668.08
354	Хангамжийн материал	73,967,717.08	90,132,668.08
35410	Бичиг хэргийн материал	304,760.00	304,760.00
35420	Аж ахуйн материал	52,272,201.20	65,428,552.20
35440	Түлш, шатах тослох материал	2,613,800.00	5,600,000.00
35470	Бусад хангамжийн материал	18,776,955.88	18,799,355.88
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>989,632,078.07</u>	<u>1,055,706,806.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	989,632,078.07	1,055,706,806.54
392	Биет хөрөнгө	928,238,077.87	993,912,806.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	808,614,533.18	890,174,533.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(31,159,591.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	126,360,047.96	128,719,380.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,266,639.47)	(71,658,747.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,440,467.70	40,340,467.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,831,831.50)	(12,623,652.58)
39209	Зам, гүүрийн байгууламж	10,260,000.00	30,260,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,998,500.00)	(4,299,583.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,660,000.00	24,160,000.00
393	Биет бус хөрөнгө	61,394,000.20	61,794,000.00
39301	Програм хангамж	193,121.00	593,121.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(193,120.80)	(193,121.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	61,394,000.00	61,394,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,064,967,098.15</u>	<u>1,145,839,474.62</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,064,967,098.15</u>	<u>1,145,839,474.62</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,064,967,098.15	1,145,839,474.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	306,936,662.93	306,936,662.93
51101	Өмч: - төрийн	306,936,662.93	306,936,662.93



512	Хуримтлагдсан үр дүн	104,979,521.27	185,851,897.74
51210	Өмнөх үеийн үр дүн	32,037,836.27	104,979,521.27
51220	Тайлант үеийн үр дүн	72,941,685.00	80,872,376.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	653,050,913.95	653,050,913.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,064,967,098.15</u>	<u>1,145,839,474.62</u>

СТ-2А

3.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	504,830,715.77	590,335,333.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	126,255,104.77	554,595,333.00
120	Нийтлэг татварын бус орлого	126,255,104.77	121,719,333.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	126,255,104.77	121,719,333.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	126,255,104.77	121,719,333.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	432,876,000.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	432,876,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	378,575,611.00	35,740,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,180,800.00	240,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	700,000.00	240,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	35,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	35,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	431,744,070.85	509,462,956.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	431,744,070.85	509,462,956.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	407,870,688.31	500,664,508.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	241,122,960.29	333,579,297.39
210101	Үндсэн цалин	203,604,315.34	262,844,710.39
210102	Нэмэгдэл	-	37,481,200.00
210104	Урамшуулал	9,816,867.95	33,253,387.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,640,888.00	41,797,490.97
210201	Тэтгэврийн даатгал	20,810,924.81	28,542,941.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,437,419.84	3,382,767.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,015,182.80	2,587,522.54
210204	Ажилгүйдлийн даатгал	488,895.96	592,164.23



Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	4,888,464.60	6,692,094.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,984,638.00	26,499,662.00
210301	Гэрэл, цахилгаан	3,375,134.00	3,314,200.00
210302	Түлш, халаалт	24,955,804.00	20,531,762.00
210303	Цэвэр, бохир ус	2,653,700.00	2,653,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,058,398.00	4,649,989.00
210401	Бичиг хэрэг	303,300.00	806,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,060,100.00	3,013,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	343,200.00	57,800.00
210404	Ном, хэвлэл	-	77,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,351,798.00	694,749.00
2105	Нормативт зардал	32,437,700.00	32,425,365.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	103,900.00	119,000.00
210502	Хоол, хүнс	32,333,800.00	32,306,365.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,336,000.00	1,341,900.00
210604	Урсгал засвар	3,336,000.00	1,341,900.00
2107	Томилолт, зочны зардал	350,000.00	700,000.00
210702	Дотоод албан томилолт	350,000.00	700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	993,300.00	1,960,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	813,300.00	1,575,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	385,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,946,804.02	57,710,504.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,631,450.00	1,356,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	773,220.00	709,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,542,134.02	55,644,604.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,873,382.54	8,798,447.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,821,611.00	8,794,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,658,600.00	8,794,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,771.54	3,647.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,771.54	3,647.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	73,086,644.92	80,872,376.47
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	72,941,685.00	80,872,376.47

СТ-2А

3.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	378,575,611.00	468,616,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	432,676,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	432,676,000.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	432,676,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	378,575,611.00	35,940,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,180,800.00	440,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,480,800.00	200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	700,000.00	240,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	35,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	35,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	378,575,611.00	468,616,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,575,611.00	468,616,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	354,551,428.46	458,780,152.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,948,340.46	331,279,699.39
210101	Үндсэн цалин	205,429,695.51	261,315,000.00
210102	Нэмэгдэл	-	37,481,200.00
210104	Урамшуулал	9,816,867.95	32,483,499.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,304,300.00	42,729,785.97
210201	Тэтгэврийн даатгал	21,529,936.00	29,478,485.97
210202	Тэтгэмжийн даатгал	2,426,300.00	3,312,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,001,283.00	2,650,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	486,116.00	662,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,860,665.00	6,625,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,798,438.00	31,315,102.00
210301	Гэрэл, цахилгаан	3,375,134.00	4,738,200.00
210302	Түлш, халаалт	24,769,604.00	23,923,202.00
210303	Цэвэр, бохир ус	2,653,700.00	2,653,700.00



2104	Хангамж, бараа материалын зардал	3,595,800.00	6,497,400.00
210401	Бичиг хэрэг	300,000.00	782,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,060,100.00	2,608,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	343,200.00	402,800.00
210404	Ном, хэвлэл	400,000.00	103,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	492,500.00	2,600,000.00
2105	Нормативт зардал	33,917,550.00	33,731,965.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	103,900.00	119,000.00
210502	Хоол, хүнс	32,333,650.00	31,268,965.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,480,000.00	2,344,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,200,000.00	4,183,700.00
210604	Урсгал засвар	6,200,000.00	4,183,700.00
2107	Томилолт, зочны зардал	350,000.00	700,000.00
210702	Дотоод албан томилолт	350,000.00	700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	993,300.00	4,938,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	813,300.00	4,758,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,443,700.00	3,403,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,480,800.00	1,356,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	962,900.00	2,047,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,024,182.54	9,835,847.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,972,411.00	9,832,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,809,400.00	9,832,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,771.54	3,647.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,771.54	3,647.64
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

СТ-4А

3.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /



Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	306,936,662.93	653,050,913.95	104,979,521.27	0.00	1,064,967,098.15
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	306,936,662.93	653,050,913.95	104,979,521.27	0.00	1,064,967,098.15
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	306,936,662.93	653,050,913.95	104,979,521.27	0.00	1,064,967,098.15
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	306,936,662.93	653,050,913.95	104,979,521.27	0.00	1,064,967,098.15
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	306,936,662.93	653,050,913.95	104,979,521.27	0.00	1,064,967,098.15
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	80,872,376.47	0.00	80,872,376.47
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	306,936,662.93	653,050,913.95	185,851,897.74	0.00	1,145,839,474.62

ТГ

3.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	468,176,000.00	468,172,352.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,176,000.00	468,172,352.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,343,800.00	458,340,152.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,279,700.00	331,279,699.39
210101	Үндсэн цалин	261,315,000.00	261,315,000.00
210102	Нэмэгдэл	37,481,200.00	37,481,200.00
210104	Урамшуулал	32,483,500.00	32,483,499.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,731,400.00	42,729,785.97
210201	Тэтгэврийн даатгал	29,480,100.00	29,478,485.97
210202	Тэтгэмжийн даатгал	3,312,800.00	3,312,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,650,400.00	2,650,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	662,500.00	662,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,625,600.00	6,625,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,316,300.00	31,315,102.00



Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	4,738,200.00	4,738,200.00
210302	Түлш, халаалт	23,924,400.00	23,923,202.00
210303	Цэвэр, бохир ус	2,653,700.00	2,653,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,257,400.00	6,257,400.00
210401	Бичиг хэрэг	542,600.00	542,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,608,600.00	2,608,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	402,800.00	402,800.00
210404	Ном, хэвлэл	103,400.00	103,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,600,000.00	2,600,000.00
2105	Нормативт зардал	33,732,800.00	33,731,965.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	119,000.00	119,000.00
210502	Хоол, хүнс	31,269,800.00	31,268,965.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,344,000.00	2,344,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,183,700.00	4,183,700.00
210604	Урсгал засвар	4,183,700.00	4,183,700.00
2107	Томилолт, зочны зардал	700,000.00	700,000.00
210702	Дотоод албан томилолт	700,000.00	700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,938,600.00	4,938,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,758,600.00	4,758,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,203,900.00	3,203,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,356,000.00	1,356,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,847,900.00	1,847,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,832,200.00	9,832,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,832,200.00	9,832,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,832,200.00	9,832,200.00

